



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар

16/05

Номгон

Барилга худалдах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус XVI хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Баянлиг сумын Эрүүл мэндийн төвийн хөрөнгөд бүртгэлтэй 2011 онд ашиглалтад орсон эхийн амрах байрны барилгын худалдах доод үнийг 1,0 сая төгрөгөөр, Баянхонгор сумын Супрессор өрхийн Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2005 онд ашиглалтад орсон 5 дугаар багт байрлах өрхийн эмнэлгийн барилгын худалдах доод үнийг 25,0 сая төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д ДААЛГАХ нь:

2.1 Барилгын нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль журмын дагуу 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 11⁰⁰ цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 103 тоот өрөөнд зохион байгуулж орлогыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд төвлөрүүлсүгэй.


2.2 Худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэсүгэй.

2.3 Энэ тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 07 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



D:/2019/Alban bichig/НН ТОГТООЛ-2019 1180011